

НЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ДЭХ ХҮНИЙ ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ДЭХ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДЛУУД

Н.БЭГЗ

Боловсролын хүрээлэн
Хүний хөгжлийн судалгааны сектор
begznadmid@gmail.com

Хураангуй

Энэ илтгэлийн гол агуулга нь тогтвортой хөгжихийн тулд эх болсон байгаль дэлхийдээ хайр гамтай хандаж, эрүүл ухаанаар эдийн засгаа хөгжүүлэн, ухаалаг хэрэглээний зарчмаар амьдарч, хойч үеийнхнийхээ ирээдүйг хохироохгүйгээр урагшлан хөгжиж буй нийгмийг бүтээгч хүний төлөвшлийн асуудал юм.

Тогтвортой хөгжлийн философи үзэл санаа нь ирээдүй хойч үеийнхнийхээ хөгжих боломжийг алдагдуулахгүйгээр хүн төрөлхтөн өнөөгийн хэрэгцээгээ ухаалгаар хангах тухай асуудал байдаг. Тэгвэл тогтвортой хөгжлийн материаллаг болон материаллаг бус эх сурвалж нь юу вэ? гэвэл өнөөдөртөө хүн төрөлхтөн өдөр тутмын хэрэгцээний болон урт хугацааны хөгжлийн эх сурвалжаа газар дэлхийн баялгаас авч хэрэглэж байна. Цаашдаа ч нэг хэсэгтээ энэ байдал үргэлжилнэ.

Хүний хэрэглээ, байгалийн даац хэтрээд, хүн төрөлхтөн өнөөдөр байгаль дэлхийн жам ёсны хөгжил, оршихуйд сөргөөр нөлөөлөх хэмжээний хүчин зүйл болсон учраас байгаль, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн асуудал улам хурцаар тавигдаж байна. Хүн төрөлхтөн өнөөгийн хэт хэрэглээг шүтсэн ийм оршихуйн замаар цаашид явж болохгүй боллоо.

Хүний нийгэм оршин тогтнох үед аливаа үйл явц саарах, тасалдах, зогсох зэрэг саатал савалгаагүй, жигд тогтуун, байнгын өсөлттэй байх нь өөрөө хүн төрөлхтний хөгжлийн үйл явцыг тогтвортой байлгах үндэс болох ёстой. Ийм тогтвортой

хөгжсөн нийгмийг хөгжиж, зөв төлөвшсөн хүн л бүтээж байгуулна. Иймээс тогтвортой хөгжлийн боловсролын уриа нь юуны өмнө “Хүнээ хөгжүүлье. Хүнийхээ хүчээр хөгжье. Хүнийхээ төлөө хөгжье” гэсэн уриа байх ёстой (Боловсролын шинжлэх ухааны академи, 2002, 2021, х.1,170). Бид энэ уриаг “Боловсрол судлал” сэтгүүлээрээ 20 жилийн өмнөөс эхлэн сурталчилж байгаа юм.

Түлхүүр үгс: Оршихуй, өөрчлөлт, дэвшил, хөгжил, нийгмийн төлөвшил, нийгмийн хөгжил.

Нэг. Хөгжил гэх ухагдахуун

Хөгжил гэсэн ерөнхий ойлголт хүн судлал, физик, хими, биологи, нийгэм гээд судлахуйн бүхий л салбараар өөр өөрийн онцлогтойгоор илэрхийлэгддэг. Эдийн засагт ч хөгжил гэсэн категори хэд хэдэн тусдаа өөр ойлголт бий. Харин өнөө үед хүн судлал, боловсрол судлалын шинжлэх ухааны эрдэмтэд хүний хөгжлийг бие физиологийн, танин мэдэхүйн, нийгэмшлийн гэж үндсэн гурван бүлэгт хувааж үзэж байна (Бэгз нар, 2018, х.10).

Тэгвэл хөгжил гэж яг юу юм бэ? Аливаа хөдөлгөөн, өөрчлөлт, тооны өсөлт хөгжил мөн үү? Өсөлт, хөгжил юугаараа ялгаатай вэ? гээд яривал хөгжил гэсэн ойлголт нь байгаль, нийгэм дэх тооноос чанарт, нэг чанараас нөгөө дэвшилттэй чанарт, хуучнаас шинэд дэвших хөдөлгөөн, өөрчлөлт болж, улмаар төгөлдөршихийг илэрхийлдэг (Ожегов С.И. 1981, х.372). Өнөө үед философийн шинжлэх ухаанд давамгайлж буй ойлголтоор матери болон ухамсар бүхэлдээ энгийнээс нарийн луу, доод болхи тогтолцооноос илүү зохион байгуулалттай дээд тогтолцоо руу чиглэсэн урагшлах дэвшилтэт хөдөлгөөнийг хөгжил гэж үздэг (Кохановский, Золотухина, 2015, х.320).

Хоёр. Хөгжлийн талаарх онолууд

Оршин тогтнохуйд эерэг үнэт зүйл гэж үзэгддэг хөгжил нь балар эрт цагаас хүн төрөлхтний сонирхлыг татсаар, шинжлэх ухааны чухал судлагдахуун байсаар иржээ. Олон тооны нэрт сэтгэгч хөгжлийг ойлгоход амьдрал, бүтээлээ зориулж, үр дүнд

нь хөгжлийг үзэх хэд хэдэн гол онолыг бий болгосон байна (Кохановский, Золотухина, 2015, х.320). Тухайлбал,

1. Үндэстэн, соёл иргэншлийг хамарсан материаллаг үйлдвэрлэлийн уналт, өсөлт төгсгөлгүй давтан үргэлжилдэг тухай эртний грек, римийн үзэл санаанд тулгуурласан *сонгодог давтамжийн онол*,
2. Цөмийн дайн, аюулт өвчин тахал, эсвэл хүн амын огцом өсөлт зэрэг аюул заналыг агуулсан их сүйрэл рүү дэлхий ертөнц ойртож байгаа гэж үздэг *мөчлөгт хөгжлийн онол*,
3. Хөгжлийг дуусахгүй, эцэс төгсгөлгүй дэвших үйл явц гэж үздэг *шугаман хөгжлийн онол*,
4. Мөчлөгт онолын зөрчилтэй чиг баримжаа болон шугаман хөгжлийн онолын оптимист чиг баримжааны мөн чанарыг хослуулдаг *мөчлөгт шугаман хөгжлийн онол*,
5. Хүний нийгэм нь хүй нэгдэл, боол, феодализм, капиталист, социалист нийгмийг дамжин, эцэст нь коммунизмд дэвшин орно гэсэн *формацын онол* зэрэг онолууд байна (Human Resource in the Context of Regional Development, 2002, p.15). Эдгээр нь аль нэг салбарын, эсвэл тодорхой нэг орны, бүс нутгийн бус, ерөөсөө хүний нийгмийн хөгжлийн ерөнхий зүй тогтлын тухай онолууд юм.

Боловсрол, хөгжил хоёрын хооронд харилцан идэвхтэй динамик харилцаа байдаг гэж үздэг хүмүүс нь голдуу шугаман хөгжлийн онолыг дэмжигчид байдаг юм бана. Эдгээрийн дотор нийгэм судлаачдын 3 том хэсэг байх ба тэд *бүтэц-үүргийн онолчид*, *хүн капиталын онолчид*, *шинэчлэлийн онолчид* гэж хуваагддаг аж. Хүн капиталын болон шинэчлэлийн онолоор боловсрол нь хөгжлийг дэмжиж сайжруулдаг гэх ба үүнийг амьдрал дээр нотлон үзүүлэх нөхцөл байдлыг хамгийн сайн бүрдүүлдэг нийгмийн хүчин зүйл гэж үздэг аж.

Гэхдээ ямар ч сайхан онол, өөдрөг таамаглал дэвшүүллээ гэсэн, амьдрал, хөгжил байнга шулуун дардан замаар, тасралтгүй өсөлт дэвшилттэй явдаггүй. Манай гараг дээрх байгаль, нийгмийн амьдрал нь эхлэл, үргэлжлэл, төгсгөлтэй, гадаад, дотоод олон хүчин зүйлийн хамааралтай өсөлт, хөгжилт, бууралт, уналт, сэргэлт ээлжилсэн мөчлөг бүхий нарийн нийлмэл үйл явц юм. Тэгэхээр бидний нэн өнгөцхөн

төсөөлөлтэй байгаа “тогтвортой хөгжил” гэгчийн зүй тогтол юу юм, тэр нь манайх шиг оронд, манай хүмүүсийн хүмүүжил, боловсролын өнөөгийн түвшний нөхцөлд яаж үйлчлэх бол? Тогтвортой хөгжил гэдэг нь хөгжлийг дуусашгүй, эцэс төгсгөлгүй дэвших үйл явц гэж үздэг шугаман хөгжлийн онол шиг гэгээлэг, гэнэхэн мөрөөдөл биш үү? Хөгжлийн бодлого, төлөвлөлтдөө үйл явцын болзошгүй сааралт, зогсолт, уналт, сэргэлтийг бид хэр тооцож үзэж байгаа билээ гэх зэрэг нь өөрөө тодорхой хариу нэхсэн судалгааны асуудал гэж бодож байна. Тогтвортой хөгжлийн боловсролын нэн чухал хэсэг нь түүнийг судлах асуудал байх ёстой.

Гурав. Хөгжлийг бий болгогч хүн өөрөө хөгжсөн байх ёстой

Байгаль, нийгэм, эдийн засаг ямар байх нь хүний хөгжил, ухаан, ухамсраас шууд хамааралтай гэдгийг арабын эртний нэгэн мэргэн сургаалд “Илжгийг шилэн ордонд оруулаад уясан ч шээгээд баачихдаг” гэж гайхалтай илэрхийлсэн байдаг. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангахын тулд хүнээ, оюун ухааныг нь, ёс суртахууныг нь юуны өмнө хөгжүүлэх шаардлагатай гэдгийг дээрх мэргэн үг маш тодорхой хэлжээ.

Тэгвэл хүний хөгжил гэж юу билээ гэвэл анагаах ухаан, байгалийн болон нийгмийн шинжлэх ухааныхан өөр өөрийн өнцгөөс харж тайлбарладаг ч боловсролынхон бид нийгмийн гишүүн хүний хөгжлийн бодлогын амин чухал хэсэг нь дээр дурдсанчлан түүний нийгэмшлийн асуудал гэж үздэг.

Байгалийн сайханд идээшин амьдрагч адгууснаас хүнийг ялгах гол ялгаа нь нийгмийн харилцааны тогтсон хэм хэмжээ болох ёс, тэр дотроо хүний ёсны хүрээ, хязгаарт захирагдаж, ахуйгаа бүтээж амьдрах чадвар юм. Амьдралын орчин, нөхцөлөө ухаалгаар бүрдүүлэх, бусдын хэрэгцээг хохироохгүйгээр өөрийн асуудлаа шийдвэрлэх ухаан, ухамсар сууж төлөвшсөн байх асуудал энд юуны өмнө багтдаг. Үүнээс ургуулаад бодвол боловсролын үндсэн үүрэг нь *байгалийн өгөгдөхүүнд суурилсан хүний өсөлтийг хөгжил болгож дэмжих, ингэснээрээ нийгмийн амьдралд дэвшил бий болгох явдал* юм. ЮНЕСКО-оос анхлан дэвшүүлж, сүүлийн жилүүдэд дэлхий даяар мөрдөж байгаа

хөгжлийн тухай ойлголт нь Дэлхийн II дайны дараа үед эдийн засгийн хөгжлийг авч үздэг байсан бол сүүлийн жилүүдэд хүний өөрийнх нь хөгжлийг голлон авч үздэг болж өөрчлөгдөөд, боловсролоор дамжуулж хүний амьдрах чадварыг нэмэгдүүлэх агуулгатай илүү уялдаатай болж байна.

Дөрөв. Боловсрол ба хөгжлийн хооронд ямар хамаарал байдаг вэ?

Сурган хүмүүжүүлэгчид болон нийгэм, эдийн засгийн бараг бүх салбарын судалгааны төлөөлөгчид хүн амыг хөгжүүлэх хамгийн сайн арга зам бол боловсрол бөгөөд нийгмийн хөгжил нь сургалтын олон төрлөөр дэмжигдэж, хүний насан туршийн нөөцийн хөгжлийн дагуу явагддаг гэж үздэг.

Хөгжилд боловсрол чухал гэж үздэг эрдэмтэд голдуу шинэчлэлийн онолыг дэмждэг. Энэ чиглэлийн зарим эрдэмтэн шинэчлэл, өөрчлөлт бол хөгжил гэсэн үг гэж үздэг (Бэгз, 2009, х.3-8). Тэдний үзлээр хүн ам нь орчин үеийн хандлага, үнэт зүйлсийг өөртөө бий болгож хадгалаагүй нийгэм хөгжиж чаддаггүй гэнэ. Үүнтэй санал нэг байна. Гэхдээ энд шүүмжлэлтэй хандах нэг юм бол өөрчлөлт, шинэчлэлт өөрөө бүрэн утгаараа хөгжил биш. Харин хөгжилд хүрэх завсрын алхмууд гэж үзвэл үнэнд илүү нийцнэ. Миний бодоход шинэ үзэл санаанаас эерэг хандлагатай өөрчлөлт бэлтгэгдэж, түүнээс хөгжил бий болдог гэж үзэх ёстой.

Боловсрол болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хооронд шууд холбоо байдаг. Боловсрол нь хувь хүний бүтээлч байдал, хөдөлмөрийн үр дүнг сайжруулж өөрчилдөг. Боловсрол нь хувь хүнийг илүү их хөгжлийн чиглэлтэй болгодог үнэт зүйл, итгэл үнэмшил бөгөөд эцэстээ нийгмийн зан төлөв байдлыг өөрчлөх нөлөөтэй хүч болдог. Боловсрол нь шинэчлэлийн үйл явцад саад болох хандлагатай, хоцрогдсон үнэт зүйлсийг өөрчлөх юм уу дарж унтраадаг хүч юм. Хүн адгуусан гаралтай, нэлээд адгууслаг шинжтэй тул хүний бага насанд нь эдгээр шинжийг зөөлрүүлэх, зарим үед бүр дарж унтраах нийгмийн үйл ажиллагааг шашин, боловсрол, шинжлэх ухаан, хууль цааз зэрэг нийгмийн институцүүд гүйцэтгэдэг.

Боловсрол нь хүний нөөц, нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн нэг үндсэн хүчин зүйл учир нийгэм оршин тогтнох материаллаг нөхцөл болох эдийн засгийн хөгжилд ч шийдвэрлэх чухал үүрэгтэй оролцож байна. APEID (Asia Pacific Education for Intrepreneurship Development)-ийн хүрээнд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд Малайз, Непал, Солонгос, Тайландад бага сургуулийн 4-6 жилийг дүүргэсэн хөдөө аж ахуйн ажилчдын хөдөлмөрийн бүтээмж нь (*нэгж талбайгаас авч байгаа ургацаар хэмжигдсэн*) боловсролгүй хүмүүсийнхээс хавьгүй өндөр байна гэдгийг харуулсан байдаг (Tribuvan University. Research Centre for Education Innovation and Development, 2019, pp.51). Наад зах нь 4 жилийн боловсрол эзэмшсэн хүмүүс ургамлын үрийг сонгох, бордоо, шавж устгах хор хэрхэн ашиглах зэрэг орчин үеийн шинжлэх ухааны аргуудыг хөдөө аж ахуйд ашиглах чадвараараа боловсролгүй хүмүүсээс илүү гэдэг нь батлагдсан зүйл юм. Хүн амын боловсролын түвшин болон үндэсний эдийн засгийн өсөлтийн харьцаа, хамаарлын асуудлаар олон тооны судалгаа 1970-2020 оны хооронд Ази, Далайн орнуудын хүрээнд хийгдсэн бөгөөд эдгээр судалгаанд боловсролын хүртээмж, чанар нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн өсөлт сайжирч байгаа дүр зураг судалгаанд хамрагдсан нийт орнуудын хэмжээнд гарчээ (Human Resource in the Context of Regional Development, 2020, p.31).

Тав. Тогтвортой хөгжил дэх боловсролтой хүний үүрэг оролцоо

Хүний гүйцэтгэж буй үүрэг, оролцооных нь үр дүнгээс харахад тогтвортой хөгжилд хүний нийгмийн төлөвшил, ёс суртахууны хөгжил маш өндөр үүрэгтэй байдаг. Байгалиас авч төрсөн чадавх нь нийгмээс сурч эзэмшдэг хүний чадваруудын суурь болдог. Хүнд төрөлхийн хэл, соёл, математикийн шинжлэх ухааны мэдлэг, чадвар, ёс зүйн мэдрэмж, харилцааны хэм хэмжээ байдаггүй. Хүн түүнийг нийгмийн орчноос л сурч эзэмшдэг. Үүнийг боловсрол гэдэг. Боловсрол нь ухаант хүн үүссэн цагаас хойших олон арав, зуу, мянган үеийнхний бий болгосон соёл, амьдрах ухааны мэдлэг, чадвар, дадлын хуримтлалыг хүн төрөлхтний дараа дараагийн үед өвлөн дамжуулах нийгмийн механизм болж ирсэн юм (Бэгз, 2001, х.49). Боловсрол цаашдаа ч хүн төрөлхтний хөгжлийн үндсэн хүчин зүйл болж, улам хөгжин

нийгмийн үүрэг нь өсөн нэмэгдэнэ.

Боловсрол нь хувь хүнийг дотоод ертөнцөө болон хүрээлэн буй орчноо танин мэдэхэд нь тусалж, хөдөлмөрийн үйл ажиллагааны дадал олгож, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нь нэмэгдүүлдэг. Нийт нийгмийг хамарсан боловсролын орон зайн уян хатан байдал, олон талт үйл ажиллагааны хүртээмжтэй, насан туршийн байх зэрэг нь хүний төлөвшилд илүү сайнаар нөлөөлж байна. Учир нь боловсрол бол нийгэм дэх аливаа өөрчлөлтүүдийг соргоогоор мэдэрч, түүнд өөрийгөө дасгах, тулгарах бэрхшээлийг хохирол багатайгаар даван туулахад нь хүнд тусалдаг бөгөөд хүний потенциалын үндэс болох мэдлэг, туршлагыг өөртөө агуулж явдаг (Удирдлагын Академи, 2003, х.162).

Манай орны тухайд олон арван мянган хүн сүүлийн 30-аад жилд хөдөөгөөс том хотууд руу нүүдэллэж, төв суурин газар суурьшихад тэдний иргэний төлөвшлийн олон асуудал хөндөгдөж байна. Газар өмчлөх уламжлалгүйгээс босгоноос цааших нь минийх биш гэж үздэг, угаадсаа үүдээрээ гадагш цацаад өөрөө түүн дээрээ хальтарч бэртдэг (Экологийн дуудлага: оршихуйн эрх зүйн баталгаа, 2012, х.168), хэний ч биш газар дээр хэвтэж байгаа юм хэн нэгнийх гэж бодохгүйгээр “олсон юм” гэж авдаг. Гэтэл өөрийн чинь гэсэн юм өөр хэн нэгний олз болдог ... зэрэг нь олуулаа нэг дор бөөгнөрөн амьдрах соёл, ёсзүйн хэм хэмжээнд хангалттай суралцаагүй нүүдэлчин удамтай монголчууд бидэнд энэ нь соёлын үнэт өв гэхээсээ илүүтэйгээр нийтлэг соёл, иргэншилд дэвшиж, дэлхийн бусад улс үндэстний зиндаанд аятай таатай амьдрахад саад болж байгаа сөрөг хүчин зүйл гэж үзэж, түүнтэйгээ тэмцэх хэрэгтэй болж байгааг харуулж байна (Бэгз, 2013, х.135).

Иргэний нийгмийн чухал үнэт зүйлс болсон хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш эрх, үүрэг хариуцлагыг ард иргэд эзэмших, эдлэх, хэрэгжүүлэх нь гагцхүү тодорхой түвшний боловсрол, мэдлэг, практик үйлдлийн үндсэн дээр л боломжтой болно. Ингэж сурган боловсруулж, ухаан ухамсар суулгахгүй бол зөвхөн өөрийгөө гэсэн аминч, адгуусан чанарт хөтлөгдөж, амьдралынхаа их орчин болсон байгаль дэлхийнхээ нөхөн

сэргээгдэхгүй баялгийг бид өөрсдөө хайр гамгүй дураар ашиглаж сүйтгэх нь сүүлийн үед ердийн явдал болж хавтгайрч байна.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангана гэвэл хүнийг хайрлах, соёлтой харилцах, хамтран суралцаж, ажиллаж амьдрах, хувийн болон нийгмийн сонголтоо зөв тэнцүүлж хийх, бусдад дараа болохгүйгээр амьдралаа аваад явах, зөв шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх зэрэг чухал чанаруудыг оюуны болон практик үйлдлийн хувьд иргэдэд төлөвшүүлж, хүнийг хөгжүүлэхэд илүүтэй чиглүүлж байх ёстой юм шиг байна.

Боловсрол бол манай өнөөгийн нөхцөлд иргэдэд хүн, байгаль, нийгмийн харилцан уялдаат амьдралын мөн чанарыг танин мэдүүлэх, байгаль, нийгмээс зөвхөн авах биш, бас аваатай өгөөтэй амьдрах соёлыг эзэмшүүлэх, сэтгэлгээний ийм зөв логик суулгах арга хэрэглүүр учир нийгмээ төгөлдөржүүлэн хөгжүүлэх институтийн чухал үүргийг гүйцэтгэж байгаа юм.

Боловсролыг олон өнцгөөс авч үздэг ч өнөөдөр боловсролын тухай суурь ойлголт шинэчлэгдлээ. Хүн өөрийнхөө тухай, хүмүүсийн харилцааны тухай, хүрээлэн буй орчныхоо тухай, ялангуяа нийгэм, соёлын уламжлал, шинэчлэлийн тухай шинжлэх ухааны мэдлэг, чадвар, үнэлэмж, хандлага эзэмшихээс гадна бусадтай харилцах, хамтарч амьдрах ажил хэрэгч чадвар, хувь хүний хөгжил, зөв төлөвшлийг олж, өөрийн болон нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул нийгэмд боловсролын үнэ цэн, үнэлэмж үргэлж өсөн нэмэгдэж байна.

Гэтэл бидний хувьд, боловсролын үйл ажиллагаандаа суралцагчдад дэвшилтэт ёсны тухай, хүний ёс, ёсзүй, ёс суртахууныг онолын хувьд л ярихаас биш, түүнийг нийгмийн харилцааны хэм хэмжээ, ёс заншил болгож хүүхэд залуучууд, нийт иргэдэд өдөр тутмынх нь амьдралын хэвшил болгож төлөвшүүлэх тал дээр олигтой ажилладаггүй юм шиг байна. Мөн бидний боловсрол, сургалтын үйл ажиллагаа нь мэдээлэл, мэдлэг төдийхөнд эргэлдээд, хэрэглээний чадвар, дадал, хандлага болж хүний хүмүүжил төлөвшилд төдийлөн наалддаггүй байж магадгүй. Боловсролын тухай бидний ерөнхий яриа, уриа лоозон газар дээрээ буухгүй байна.

Нөгөө талаар боловсрол гэхээр хүний толгойд зөвхөн анги, хичээлийн 8 цагийн асуудал л буудаг хэвээр байна. Сургуулийн гаднах боловсролын орон зай, түүнийг хамарсан үндэсний хэмжээний насан туршийн боловсролын сүлжээ манайд бий болж төлөвшөөгүй нь насанд хүрэгчид, ахмад настан, ажилгүйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэрийн эзэгтэй, өндөр настан зэрэг нийгмийн бүлгүүд боловсролын бодлогын гадна орхигдоход хүрээд байна. Боловсролын статистикийн нэгдсэн сангийн мэдээллээс харахад манай боловсролын бодлогын хамрах хүрээ 22-23 насныхнаар үндсэндээ дуусгавар болж, түүнээс цааших насныхан боловсролын бодлого, төлөвлөлт, зохицуулалт, удирдлага, санхүүжилтийн гадна үлдэж байгаа нь харагдаж байна. Ийм учир монголын нийгмийн төлөвшил, ёс суртахууны байдлыг боловсролын зорилгын үүднээс харж, нэг их гайхаад байх юмгүй гэж үзэж болно.

Зургаа. Боловсрол ба глобал орчин дахь монгол хүний өрсөлдөх чадвар

Шинэ мянганы эхэнд монголчууд бид хөгжлийн глобал орчинд бусад олон улс үндэстэнтэй зэрэгцэн аж төрж байна. Энэ байнга хурдтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа шинэ орчин нь бид бүхнээс бүтээлч өндөр чадвар, нийтээр хүлээн зөвшөөрсөн глобал ёс зүйн хэм хэмжээг шаардаж байгаа юм.

Гэтэл энэ ертөнцөд нийтээр хамтран амьдрахад хүнд огт байж боломгүй олон муу шинжийг бид үзүүлсээр байна. Монголчуудын хувьд төр, засагтаа, эсвэл шашинд хувь заяагаа даатгах, үгүй бол амьдрал, ахуйгаа тэрүүхэндээ хувь хувьдаа төвхнүүлэх гэж ганц ганцаар тэмцэх, бусдын үзэл бодлыг үл тэвчих, үйл явцын зөвхөн сүүдэртэй хар талыг олж харах, өөрөөсөө бусдыг хүлээн зөвшөөрөхгүй бүгдийг хавтгайруулан шүүмжлэх зэрэг нь бидний туулж өнгөрүүлсэн өмнөх нийгмүүдийн сөрөг үр дагавар боловч өнөөдөр бид хамтын хүчээр засаж залруулбал зохих муу шинжүүд юм.

Шударга ёс, хамтын оюун бодолд тулгуурласан үнэн зөв шийдвэр, өрсөлдөх өндөр чадвар нь сүүлийн жилүүдэд манай залуу үеийнхний мэдлэг, чадвартай ухаалаг цөөнх хэсгийн сонголт болж

байна. Гэвч үүнд найдаж, нийт хүн ам аяндаа, урсгалаараа, гаднын туршлага жишээгээр, ЮНЕСКО-ийн уриа дуудлагаар тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч болж өөрөө төлөвшинө гэж эндүүрч болохгүй. Өөрөөр хэлбэл, албан боловсролын анги танхим хавийн, голдуу тоон өсөлтөд чиглэсэн зорилтуудаар нийт хүн амын хөгжил, төлөвшлийн асуудал шийдэгдэхгүй гэсэн үг.

Зүй нь бид бага сургуульдаа монгол хүний төлөвшлийн суурийг тавьж, дунд ангиудад суралцагчдаа хүний сэтгэн бодох, ертөнцийг таних шинжлэх ухааны мэдлэгийн суурийг өгөөд, ахлах анги, дундын дараах шатны боловсролоор ажил мэргэжлийн боловсрол өгч, залуучуудаа амьдралд чанартай сайн бэлтгээд, цаашид насан туршид нь тасралтгүй хөгжүүлж чадвал зэргэлдээх Орос, Хятад, Япон, Солонгосоос дутахгүй хүмүүжил боловсролтой байж болох уламжлал, байгалийн өгөгдөхүүнтэй үндэстэн шүү дээ бид. Одоогийн байдлаар монгол хүн гадаадад гараад дийлэнх нь хамгийн үнэлгээ муутай хар бор ажил хийж, амь зууж байгааг бид хаа хаанаа сайн бодох ёстой.

Хүн амын дийлэнх хэсэг нь хот суурин газар амьдарч байгаа манай өнөөгийн практикт иргэдийг суурьшуулах, хотжуулах, иргэншүүлэх, хөгжүүлэх гэсэн мөчлөг, дэс дараалал бүхий сургалтын цогц үйл ажиллагааг нийт хүн амд хүртээмжтэй хэлбэрээр явуулах шаардлагатай. Мөн хөдөөгийн хүн амд энэ боловсролыг тасралтгүй бодлоготойгоор хүргэж үйлчлэх, үр дүнг нь тооцож байх нийгмийн механизмыг бүрдүүлэх нь глобал дулаарал, нутаг дэвсгэрийн цөлжилт, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайг дагасан байгаль орчны сүйтгэл зэрэг монгол нүүдлийн соёл, монгол үндэстний оршихуйд заналхийлэх олон асуудлыг шийдэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болно. Энэ зорилтыг бүх нийтийг хамарсан албан, албан бус насан туршийн боловсролоор л хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал, хиймэл оюуны эринд ухаалаг хотод амьдрах, эд юмсын интернэтээр харьцах, боловсролыг цахимжуулах зэрэг нь өнөөгийн залуу, дунд, ахмад насныхны хөгжлийн бодлогын нэн чухал чиглэл болон дэвшигдэж байна. Энэ нь манайд одоо хийгдэж байгаа эдийн засгаа сэргээж, их бүтээн байгуулалт өрнүүлэх, амьдралын сайхан орчин бүрдүүлэх

эдийн засгийн тогтвортой хөгжлийн үйл хэрэгтэй эн чацуу ач холбогдолтой том зорилт юм.

Дүгнэлт

Иргэншсэн нийгмийн амьдралын хэм хэмжээ, идеал нь гадаадад олон зууны туршид, хүнд бэрх замыг туулж, хатуу сургамжийг үлдээн байж төлөвшсөн, хүн төрөлхтний хөгжлийн нэн их үнэт зүйлс юм. Тэдгээрийг төлөвшүүлж, хөгжүүлэхэд боловсролын оруулж ирсэн хувь нэмрийг зөв тооцож, хөгжлийн бодлогыг нь олон улсын нийтлэг жишиг, монгол үндэстнийхээ өвөрмөц онцлогийн уулзвар дээр авч үзэх замаар өнөөгийн нийгэмд тулгамдаж буй тогтвортой хөгжлийн соёлыг төлөвшүүлэхгүй бол улс үндэстний хөгжилд сөргөөр нөлөөлнө.

Хагас нүүдлийн нийгмээс хотжих үйл явцад хурдтай татагдан орж байгаа манай иргэдэд шинэ зууны тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх нь цаг хугацаа, хөрөнгө зардал шаардсан, урт хугацааны үйл ажиллагаа юм. Энэ хэрэгт олон түмний ухамсартай дэмжлэгийг олох, тэдний оролцоог дээшлүүлэх нь тавьсан зорилгыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Тэгж чадаж гэмээ нь байгаль, нийгмээ эзний ёсоор хайрлан хамгаалж, ирээдүй цагийг хохироолгүйгээр өнөөгийн хэрэгцээгээ бүрэн дүүрэн хангах ухаалаг хэрэглээний соёлыг нийгмийн гишүүдэд төлөвшүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд үүнийг хүн амын насан туршийн боловсрол л шийднэ гэдэгт эргэлзэхгүй байж болно.

Талархал

Боловсронгүй, тогтвортой хөгжсөн нийгэм байгуулахад боловсролтой хүний гүйцэтгэх үүргийн тухай үзэл бодлоо нийгэмд хүргэж түгээх боломж олгосон хүмүүст талархлаа илэрхийлье.

Номзүй

Боловсролын шинжлэх ухааны академи.(2002). *Боловсрол судлал, 2002/1-2021/170*. Улаанбаатар.

БСШУСЯ. (2011). Монгол Улсад орчин цагийн боловсрол үүсэж хөгжсөний 90 жил. *Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.

- Бэгз Н. нар. (2018). *Хүүхэд, залуучуудын хөгжлийн онол, аргазүй*. Улаанбаатар.
- Бэгз Н. (2009). Боловсрол ба хөгжил. *БС-2009/11/3-8*. Улаанбаатар.
- Бэгз Н. (2001). *Глобалчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд*. Улаанбаатар.
- Бэгз Н. (2013). *Монголын боловсрол судлалын шинэ парадигм*. Улаанбаатар.
- Ожегов С.И. (1981). *Словарь русского языка*. Москва.
- Кохановский В.П., Золотухина Е.В. и др. (2015). *Шинжлэх ухааны философи*. Улаанбаатар.
- Удирдлагын Академи.(2003). *Удирдлагын онол, практикийн асуудлууд*. Улаанбаатар.
- Экологийн дуудлага: оршихуйн эрх зүйн баталгаа. (2012). х.168. Улаанбаатар.
- Human Resource in the Context of Regional Development. FTF, 2002
- Tribuvan University. (2019). *Education and Development*. Research Centre for Education Innovation and Development, Cathmandu, Vol.24. pp.51

Human development issues in sustainable development

Begz.N

Mongolian Institute for Educational Research

begznadmid@gmail.com

Abstract

In order to to achieve sustainable development, it is important to love the mother nature, develop the economy with common sense, live by the principles of smart consumption, and build a society that moves forward without compromising the future of our next generations. First, we must address the issues of human development, which are main factors of the sustainable development of today and in the future. To develop a person means to talk about education. This will provide an opportunity to define human roles and responsibilities for the sustainable development.

The concept of the sustainable development is a process of meeting current needs without compromising the development opportunities of future generations. So what is development and what is sustainable development? The material source of the sustainable development is that today, human beings use the earth resources for their daily needs and long-term development.

Human development is achieved through education. A developed person builds a developed society. That is why the motto of education for sustainable development is "Let's develop people. Let's be developed by human power. Let's develop for the sake of our people." Providing education for sustainable development to Mongolians who are rapidly becoming more and more involved in the process of urbanization from a semi-nomadic society is a time-consuming and long-term process. In our current practice, where the majority of the population is living in urban areas, it is necessary to develop and implement a policy to solve the complex process of resettlement, urbanization, civilization, and development through lifelong learning. This cannot be addressed in formal

education alone. This development goal needs to be considered and addressed in line with the Sustainable Development Goals-4 Education 2030 Plan.

Key words: Existence, reform, progress, development, social formulation, soviai development.